

САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН ОЛОН УЛСЫН СТАНДАРТЫН ТОЙМ

СТОУТХ Тайлбар 23 – Орлогын Татварын Бүртгэлийн Тодорхойгүй Байдал



Ерөнхий мэдээлэл

2017 оны 6 сард СТОУТХ 23 – Орлогын Татварын Бүртгэлийн Тодорхойгүй Байдал тайлбарыг НББОУСЗ-өөс гаргасан.

Уг Тайлбарт орлогын татварын байр суурьтай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдолд НББОУС 12 Орлогын Татвар-ын хүлээн зөвшөөрөлт ба хэмжилтийн шаардлагуудыг хэрхэн ашиглах талаар тайлбарласан ба үүгээр дараах дөрвөн асуудлыг шийдвэрлэнэ:

- Аж ахуйн нэгж нь тодорхой бус татварын байр суурийг тусад нь авч үзэх эсэх;
- Татварын албанаас хийж буй татварын шалгалтын талаар аж ахуйн нэгжийн хийх хэрэгтэй төсөөлөл;
- Татвар ногдох ашиг эсвэл алдагдал, татварын суурь, ашиглаагүй татварын алдагдал, ашиглаагүй татварын хөнгөлөлт ба татварын хувь хэмжээ зэргийг аж ахуйн нэгж хэрхэн тодорхойлох тухай; ба
- Хүчин зүйлс ба нөхцөл байдалд орсон өөрчлөлтийг аж ахуйн нэгж хэрхэн авч үзэх тухай.

СТОУТХ 23-ын шаардлагуудын талаар энэхүү СТОУС-ын Тоймд хураангуйлан харуулав.

СТАТУС

Эцэслэсэн

ХҮЧИН ТӨГӨЛДӨР ХЭРЭГЖИЖ ЭХЛЭХ ӨДӨР

2019 оны 1 сарын 1

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН НӨЛӨӨ

Орлогын татварын хөрөнгө ба өр төлбөрийн хэмжилт болон тодруулгад нөлөөлөх магадлалтай

Шийдлүүд

Аж ахуйн нэгж нь тодорхой бус татварын байдлыг тусад нь авч үзэх эсэх

Тодорхой бус байдлыг шийдвэрлэх шийдлийг хамгийн сайн таамаглаж байгаа аргаас хамаарч тодорхой бус татварын бүртгэлийг тусад нь эсвэл нэгтгэж бүртгэхийг СТОУТХ 23 шаарддаг. Хамгийн тохиромжтой аргыг тодорхойлохдоо аж ахуйн нэгж нь дараах зүйлсийг харгалзан үзэх боломжтой:

- Аж ахуйн нэгж нь орлогын албан татварын тайлангаа хэрхэн бэлтгэдэг; ба
- Татварын албанаас эдгээр асуудлуудыг хэрхэн шалгаж, шийдвэрлэнэ гэж үзэж байгаа талаар.

Татварын албаны хяналт шалгалт

Өнөөгийн болон хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг хэмжихдээ татварын албанаас хийх хяналт шалгалтын явцад тэд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд бүхий л үнийн дүнг шалгах ба холбогдох бүх мэдээллийн талаар бүрэн мэдлэгтэй байна гэсэн төсөөллийг ашиглахыг СТОУТХ 23 шаарддаг.

Татвар ногдох ашиг (татварын алдагдал), татварын суурь, ашиглаагүй татварын алдагдал, ашиглаагүй татварын хөнгөлөлт ба татварын хувь хэмжээг тодорхойлох

СТОУТХ 23-аар шаардсаны дагуу аж ахуйн нэгж нь тодорхой бус татварын зохицуулалттай холбоотой бүртгэлийг татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтай эсэхийг үнэлэх ёстой. Хэрэв татварын алба хүлээн зөвшөөрөх магадлалтай бол татвар ногдох ашиг (татварын алдагдал), татварын суурь, ашиглаагүй татварын алдагдал, ашиглаагүй татварын хөнгөлөлт ба татварын хувь хэмжээ нь аж ахуйн нэгжийн орлогын тайлан бэлтгэхэд ашигласан эсвэл ашиглахаар төлөвлөсөн бүртгэлтэй нийцэж байх ёстой юм. Хэрэв татварын алба зөвшөөрөх магадлалгүй гэж үзсэн бол аж ахуйн нэгж нь дараах хоёр арга замын аль нэгийг нь сонгож тодорхой бус байдлыг тусгана:

- **Таамагласан үнийн арга.** Жишээ нь, аж ахуйн нэгж нь үнэ шилжилттэй холбоотой зардлыг татвар ногдох орлогоос хасагдах зардал гэж тайлагнасан ба энэ тайланг татварын албанаас зөвшөөрөхгүй байх магадлалтай гэж дүгнэсэн гэж үзэе. Хэрэв тодорхой нэг үнэ шилжилтийн асуудалд татварын албанаас гаргах шийдвэр нь бусад үнэ шилжилтийн асуудалд нөлөөлнө гэж аж ахуйн нэгж үзвэл орлогын татварын хөрөнгө ба өр төлбөрийг хэмжихдээ татварын албаны хийх хяналт шалгалтаас үүсч болох боломжит үр дүнгүүдийн магадлан жигнэсэн дундаж үр дүнг тооцох хэрэгтэй.

- **Хамгийн боломжит арга.** Жишээлбэл, аж ахуйн нэгж нь 100,000 төгрөгөөр биет бус хөрөнгө худалдаж авсан бөгөөд татварын хөнгөлөлт авна гэдэгдээ итгэлтэй байгаа. Гэхдээ уг хөнгөлөлтийг худалдан авсан жилдээ 100% авах эсвэл ирэх 5 жилийн хугацаанд жил бүр 20%-иар авах боломжтой. Хэрэв аж ахуйн нэгж нь тайлант жилд 100% хөнгөлөлт авахаар тооцож тайлангаа бэлдсэн ч татварын албанаас 5 жилийн хугацаанд 20%-иар хөнгөлөлт авахыг л зөвшөөрнө гэж үзвэл тайлант жилийн татварын хөнгөлөлт нь 20% байна гэсэн төсөөлөлд үндэслэн тайлант жилийн татварын байдлаа аж ахуйн нэгж нь хэмжинэ. Хойшлогдсон татварын байдал нь 0%-иар биш харин 80%-тай тэнцэх хөрөнгийн татварын сууриар төсөөлнө.

Хүчин зүйлс ба нөхцөл байдалд өөрчлөлт орох

СТОУТХ 23-д заасан тодорхой бус татварын бүртгэлээр аж ахуйн нэгжийн тушаасан татварын тайланг татварын алба хүлээн зөвшөөрөх эсэх тухай тооцоолол ба шийдэл гаргахыг шаарддаг. Хэрэв тухайн тооцоолол ба шийдлийг тодорхойлоход суурилсан хүчин зүйлс, нөхцөл байдалд өөрчлөлт орсон, эсвэл шинэ мэдээлэл нь тооцоолол, шийдэлд нөлөөлөх бол тооцоолол ба шийдлүүдийг дахин үнэлэхийг СТОУТХ 23-аар шаарддаг. Ийм өөрчлөлтийн нөлөөг НББОУС 8 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого*, *Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* стандартын дагуу тусгана. Үүнээс гадна тайлагналын өдрийн дараа гарсан үг өөрчлөлт нь залруулах эсвэл залруулахгүй үйл явдал эсэхийг тодорхойлохдоо НББОУС 10 *Тайлагналын Өдрийн Дараах Үйл Явдал* стандартыг мөрдөх хэрэгтэй.

Тодруулга

Орлогын татварын бүртгэлтэй холбоотой тодорхой бус байдал байгаа үед дараах тодруулгыг хийхийг СТОУТХ 23 шаарддаг:

- НББОУС 1 *Санхүүгийн Тайлангийн Толилуулга*-н 122-р зүйлийн дагуу татвар ногдох орлого эсвэл алдагдлыг тодорхойлоход гаргасан шийдлүүд.
- НББОУС 1-ийн 125-129-р зүйлийн дагуу хийсэн төсөөлөл ба тооцооллын талаарх мэдээлэл.

Үүнээс гадна тодорхойгүй татварын бүртгэлийн татварын алба зөвшөөрөх магадлалтай бол тухайн тодорхой бус байдлын болзошгүй нөлөөг НББОУС 12 *Орлогын Татварын* 88-р зүйлийн дагуу татвартай холбоотой болзошгүй зүйл гэж тодруулах хэрэгтэй эсэхийг аж ахуйн нэгжийг үнэлэхийг СТОУТХ 23 шаарддаг.


Шилжилт

Анх удаа мөрдөж эхлэхдээ аж ахуйн нэгж нь СТОУТХ 23-ыг дараах байдлаар хэрэгжүүлж болно:

- НББОУС 8 *Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлого, Тооцооллын Өөрчлөлт ба Алдаа* стандартын дагуу буцаан мөрдөж; эсвэл
- Буцаан мөрдөх аргыг ашиглах бөгөөд анх мөрдөж эхэлсэн өдрөөр хуримтлагдсан ашгийн эхний үлдэгдэлд тохируулах замаар хуримтлагдсан нөлөөг хүлээн зөвшөөрнө (СТОУТХ 23-ыг анх мөрдөж эхэлсэн санхүүгийн жилийн эхлэл). Энэ тохиолдолд зэрэгцүүлэгдэх мэдээллийг дахин илэрхийлэхгүй.

Хүчин төгөлдөх хэрэгжиж эхлэх хугацаа

СТОУТХ 23 нь 2019 оны 1 сарын 1-ний өдөр эсвэл түүнээс хойших тайлагналын үед хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.



This publication has been carefully prepared, but it has been written in general terms and should be seen as broad guidance only. The publication cannot be relied upon to cover specific situations and you should not act, or refrain from acting, upon the information contained therein without obtaining specific professional advice. Please contact your respective BDO Member Firm to discuss these matters in the context of your particular circumstances. Neither BDO IFR Advisory Limited, Brussels Worldwide Services BVBA, BDO International Limited and/or BDO Member Firms, nor their respective partners, employees and/or agents accept or assume any liability or duty of care for any loss arising from any action taken or not taken by anyone in reliance on the information in this publication or for any decision based on it.

Service provision within the international BDO network of independent Member Firms ('the BDO network') in connection with IFRS (comprising International Financial Reporting Standards, International Accounting Standards, and Interpretations developed by the IFRS Interpretations Committee and the former Standing Interpretations Committee), and other documents, as issued by the International Accounting Standards Board, is provided by BDO IFR Advisory Limited, a UK registered company limited by guarantee. Service provision within the BDO network is coordinated by Brussels Worldwide Services BVBA, a limited liability company incorporated in Belgium with its statutory seat in Zaventem.

Each of BDO International Limited (the governing entity of the BDO network), Brussels Worldwide Services BVBA, BDO IFR Advisory Limited and the Member Firms is a separate legal entity and has no liability for another such entity's acts or omissions. Nothing in the arrangements or rules of the BDO network shall constitute or imply an agency relationship or a partnership between BDO International Limited, Brussels Worldwide Services BVBA, BDO IFR Advisory Limited and/or the Member Firms of the BDO network.

BDO is the brand name for the BDO network and for each of the BDO Member Firms.

© 2018 BDO IFR Advisory Limited, a UK registered company limited by guarantee. All rights reserved.

www.bdo.global

www.bdo.mn

